



**УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ**

2019 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/109

Улаанбаатар хот

**Нөхөн сэргээлтийн ажлыг хүлээж авах
ажлын хэсэг байгуулах тухай**


Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм", Засгийн Газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм", Нийслэлийн засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Нийслэлийн засаг даргын 2014 оны А/926 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан "Авто зам, тохижилт, ногоон байгууламжийг ашиглах, хамгаалах журам", Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.9.5, 3 дугаар зүйлийн 3.1.12 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Авто зам, замын байгууламж, тохижилт, ногоон байгууламжийг сэтлэх, сүвлэх, орц гарц гаргах зөвшөөрөл олгосон ажлын мөрөөр авто зам, замын байгууламж барих, засварлах болон тохижилт, ногоон байгууламжийн нөхөн сэргээлтийн тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, ажлын гүйцэтгэлд хяналт тавих ажлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу зохион байгуулахыг Инженерийн байгууламжийн хэлтэс /Т.Хэрлэн/-т үүрэг болгосугай.

2. "Авто зам, тохижилт, ногоон байгууламжийг ашиглах, хамгаалах" журмын дагуу авто зам, замын байгууламж, тохижилт, ногоон байгууламжид хийгдсэн нөхөн сэргээлтийн ажлыг холбогдох дүрэм журмын дагуу ашиглалтад хүлээн авах үүрэг бүхий Ажлын хэсгийг хавсралт ёсоор байгуулсугай.

3. Ажлыг ашиглалтад хүлээн авч ашиглалт хариуцсан байгууллагад хүлээлгэн өгч, хэрэгжилт үр дүнг тухай бүр тайлагнаж ажиллахыг Ажлын хэсэг /Т.Хэрлэн/-т даалгасугай.


4. Авто зам, замын байгууламж, тохижилт, ногоон байгууламжийг сэтлэх, сүвлэх, орц гарц гаргах зөвшөөрөл олгосон ажлын мөрөөр авто зам, замын байгууламж барих, засварлах болон тохижилт, ногоон байгууламжийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэгч байгууллагад 2019 онд албаны нэмэлт дансанд нөхөн сэргээлтийн зориулалтаар төвлөрүүлсэн хөрөнгөөс гүйцэтгэлээр санхүүжүүлж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 04 сарын 19
өдрийнтушаалын хавсралт

А/109



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Т.Хэрлэн

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны
Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга

Гишүүд:

П.Чойжилжав

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны
Аудит, дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн

Д.Сүхбат

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны
Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн
мэргэжилтэн

Э.Сүлд-Эрдэнэ

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны
Инженерийн байгууламжийн хэлтсийн
мэргэжилтэн

Э.Мөнх-Од

Нийслэлийн Авто замын Хөгжлийн газрын
Засвар ашиглалтын хяналтын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

Б.Басхүү

Нийслэлийн Авто замын Хөгжлийн газрын
Засвар ашиглалтын хяналтын хэлтсийн
мэргэжилтэн